

## ХҮҮХДИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН ТАЛААРХ ТАНДАЛТ СУДАЛГАА

Ц. Болд

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим магистр ахлах багш  
<https://orcid.org/0000-0002-5765-4254>

Б. Баттогтоо

<https://orcid.org/0009-0000-8582-5076>

А. Тэнүүнжаргал

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, магистр багш  
<https://orcid.org/0000-0003-3831-1325>

**Abstract:** *This scoping review explores the multi-dimensional construct of child well-being, with a specific focus on psychological and subjective well-being among school-aged children in Mongolia and beyond. Drawing from 19 empirical studies identified through comprehensive searches in eight databases, the review synthesizes key factors contributing to children's well-being, including perceived social support, school climate, parental relationships, autonomy, and socioeconomic status. The findings underscore that supportive social environments, particularly those fostering autonomy, competence, and belonging, significantly enhance children's life satisfaction and mental health. Conversely, experiences of discrimination, psychological control, and economic hardship negatively impact children's well-being. Notably, only one study was based in Mongolia, highlighting a critical research gap. This review contributes to a nuanced understanding of the relational and contextual determinants of child well-being and lays the groundwork for more culturally grounded research in Mongolia. It also emphasizes the need for ethical, participatory, and methodologically diverse approaches in future studies.*

**Key words:** *child, psychological and subjective well-being, social support factors*

### Удиртгал

Хүүхдийн сайн сайхан байдал зөвхөн бие махбодын эрүүл мэнд болон материаллаг нөөцөөр хязгаарлагдахгүй, хүүхдийн аз жаргал, эрүүл мэнд, сэтгэл хөдлөлийн аюулгүй мэдрэмж, өөриймсөх мэдрэмж, нийгмийн чадвар, танин мэдэхүйн хөгжил, хөгжил дэвшлийг илэрхийлэх олон олон үзүүлэлтээр тодорхойлогдох олон талт нарийн нийлмэл ойлголт ажээ. Иймд тус ойлголтыг судлахад тэдгээр хүчин зүйлс хоорондоо хэрхэн уялдаж, хүүхдийн амьдралын чанарт нөлөөлж байгааг харгалзан үзэх олон талт хандлага шаардлагатай юм (Bertram, 2016). Жаахан гүнзгийрүүлбэл сайн сайхан байдал гэдэг нь эрүүл, чадамжтай байх гэхээс илүү хувь хүний өдөр тутмын амьдралын асуудлаа зохицуулах, идэвхтэй, бүтээлч байдлаа хадгалах, нийгэмдээ утга учир бүхий хувь нэмрийг оруулах чадамжийг илэрхийлсэн өөрөөр хэлбэл хувь хүний болон хамтын чадавхыг нэмэгдүүлэхийг чухалчилдаг ойлголт юм (Aulia et al., 2020). Үүнээс гадна, сайн сайхан байдлын талаарх ойлголт нь хүмүүс хоорондын харилцаа, орчин тойронтой хэрхэн холбогдож буйтай салшгүй холбоотой бөгөөд эдгээр нийгмийн хүчин зүйлс нь социологийн үүднээс чухал ач холбогдолтой (Kemppainen, 2012) байдаг. Дүгнэвэл, сайн сайхан байдлын талаарх ойлголт нь аз жаргал, сэтгэл ханамж төдийхнөөр хязгаарлагдахгүй, эерэг сэтгэл хөдлөл, нийгмийн оролцоо, бат бөх нийгмийн харилцаа, амьдралын утга учир, амжилтаар тодорхойлогдох олон талт хэв шинжийг агуулж байдаг (NG, 2021).

Иймд тус ойлголтыг судлахдаа эдийн засгийн нөхцөл байдалтай холбосон уламжлалт үзүүлэлтээр хязгаарлахгүйгээр, хүмүүсийн амьдралын мөн чанарыг илэрхийлэх бусад үзүүлэлтүүдийг авч үзэх хэрэгтэй (Kemppainen, 2012). Сайн сайхан байдал гэх ойлголтын хүрээнд бие махбодын, сэтгэл зүйн, нийгмийн болон хүрээлэн буй орчны зэрэг харилцан уялдаа бүхий олон талт үзүүлэлтийг багтаан авч үздэг. Учир нь эдгээр үзүүлэлтүүд нь харилцан адилгүй байдлаар хүний зан хандал эсвэл аливаа үйлдэлд нөлөөлж байдаг учраас харилцан нөлөөлөлд нь цогц байдлаар ойлгох нь чухал болохыг судлаачид тэмдэглэжээ (Kiefer, 2008).

Хүүхдийн сайн сайхан байдлын тухайд, тэднийг тойрон хүрээлж буй хүмүүсийн сэтгэл зүйн дэмжлэг онцгой чухал үүрэгтэй (Griga, 2016). Хүүхдэд өөрийнхөө сайн сайхан байдлыг бүтээх боломжийг бүрдүүлэх, оролцоог нь хангах хэрэгтэй байдаг аж (Noroz, 2023). Өөрөөр хэлбэл тэдний сайн сайхан байдлыг зөвхөн гаднаас хамааралтай хүчин зүйлсээр хэмжиж тодорхойлохоос илүүтэй дотоод хүчин зүйлс буюу субъектив талыг орхигдуулахгүй авч үзэх юм. Нэмж тэмдэглэхэд хүүхдийн сайн сайхан байдлын талаарх ойлголт нь нэгдмэл байдлаар бус “амьдралын чанар”, “амьдралын сэтгэл ханамж”, “аз жаргал” гэх мэт ойлголтуудын хүрээнд тодорхойлогдон нийтлэг байдлаар судлагддаг (Richter et al., 2018). Тус нэгдсэн ойлголтын тодорхойгүй байдал нь хүүхдийн сайн сайхан байдлыг ялгаатай нийгмийн нөхцөлд үнэлж судлах нийтлэг жишиг шалгуур үзүүлэлтүүдийг тогтооход хүндрэлтэй болгодог. Учир нь сайн сайхан байдлын онолын тодорхойлолт болон өдөр тутмын амьдралд илэрхийлэгдэх хэлбэр нь энэ ойлголтын субъектив болон тодорхой нөхцөл байдлаас хамааралтайгаар тодорхойлогдох онцлог шинж чанартай нь холбоотойгоор тайлбарлагддаг (Jarden & Roache, 2023). Ерөнхийдөө хүүхдийн сайн сайхан байдал нь материаллаг нөөц, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын хүртээмж зэрэг бодит хүчин зүйлсээс гадна, хүүхдийн өөрийнх нь амьдралын талаарх мэдрэмж, бусадтай харилцах харилцаа, өөрийгөө үнэлэх үнэлэмж зэрэг субъектив хүчин зүйлсээс хамааралтайгаар судлагддаг. Ингэхдээ нийгэм-хүн амзүйн, эдийн засгийн, соёлын болон улс төрийн хүчин зүйлсийг харгалзан үзэх нь чухал (Demiessie & Shirin, 2021).

Дээрх агуулгын хүрээнд энэхүү тандалт судалгаа нь хүүхдийн сайн сайхан байдлын талаарх өмнөх судалгааны бүтээлүүдийг шүүж, ялангуяа тэдний сайн сайхан байдалд нөлөөлөгч сэтгэл зүйн болон орчны хүчин зүйлсийг чухалчлан авч үзсэн болно. Тодруулбал, гэр бүл, үе тэнгийнхэн, сургууль болон олон нийтийн зүгээс үзүүлж буй нийгмийн дэмжлэг хүүхдийн сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохыг зорилоо. **Нийгмийн дэмжлэг нь хүүхдийн сайн сайхан байдалд хэрхэн, хэр их нөлөөлдөг вэ?** гэх хөтлөх гол асуултыг дэвшүүлж хүүхдийн сэтгэл зүйн сайн сайхан байдалд нөлөөлөгч хүчин зүйлс болон нийтлэг ашиглагдаж буй арга зүйн хандлагын зураглалыг гаргав. Цаашилбал Монголын соёлын онцлогт тохирохуйц, хүүхдийн сайн сайхан байдлын судалгааны арга зүйн чиг хандлагыг тодорхойлохыг зорилоо.

### **Тандалт судалгааны хайлтын стратеги болон сонголт хийгдсэн байдал**


Сайн сайхан байдал болон түүнийг хамаатуулан судалдаг салбар чиглэлүүдийн мэдээллийг хүртээмжтэйгээр олж авах зорилгоор 2025 оны 1-р сараас 3-р сарын 20 хүртэлх хугацаанд хайлт хийсэн ба Springer, APA PsychInfo, Elsevier, EduLearn, Frontiers, PubMed, Hipatia Press, E-library of Num зэрэг 8 мэдээллийн санг ашиглалаа. Мэдээллийн сангуудыг, сэтгэл зүй, социологийн шинжлэх ухааны бүтээлүүдийг тогтмол хэвлэн нийтэлдэг гэсэн шалгуурт үндэслэн сонгосон болно. Бид мэдээллийн сангаас хайлт хийхдээ дараах түлхүүр үгсийг ашигласан. Үүнд:

"ХҮҮХЭД", "ӨСВӨР НАС", "СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХЭД", "САЙН САЙХАН БАЙДАЛ", "СЭТГЭЛ ЗҮЙН САЙН САЙХАН БАЙДАЛ", "СУБЪЕКТИВ САЙН САЙХАН БАЙДАЛ", "АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ", "СЭТГЭЛ ЗҮЙН ТОХИРУУЛГА" "НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ" - "АЗ ЖАРГАЛ", "НӨЛӨӨ" эсвэл "ХҮЧИН ЗҮЙЛ" "ХАМААРАЛ" "ХЭТИЙН ТӨЛӨВ".

Бид судалгааны материалын хайхдаа хугацааны тодорхой хязгаарлалт тавиагүй ба судалгааны бүтээлийн гарчиг, түлхүүр үг, хураангуй дээр төвлөрч тогтсон шалгуурын дагуу хайсан. Судалгааны хайлтыг англи, монгол хэлээр хийсэн төдийгүй энэхүү судалгаанд зөвхөн эх хувийг оруулж ашигласан болно. Системчилсэн хайлтын үр дүнг нягталсны дараа шинжилгээнд хамруулах бүтээлүүдийг доор дурдагдах шалгуурууд дээр үндэслэн, нийт 19 өгүүллийг сонголоо (Зураг 1).

Энэхүү тандалт судалгаанд хүүхдийн сайн сайхан байдлыг авч үзэхдээ:

- сэтгэлзүйн сайн сайхан байдал, субъектив сайн сайхан байдал болон сэтгэцийн сайн сайхан байдлыг судалсан бүтээлүүдийг сонгосон;
- Судалгаандаа 1-12-р ангид суралцдаг сургуулийн насны хүүхдүүдийн асуудлыг хөндсөн бүтээлийг хамруулсан;
- Сайн сайхан байдалтай холбоотой дор хаяж нэг сэтгэлзүйн үзүүлэлтийг хэмжиж буй бүтээлийг сонгосон.
- Түүнчлэн, эмпирик судалгааны үр дүнд тулгуурласан өгүүлэл, тайлан, судалгааг сонгон хамрууллаа. Харин бие махбодын болон оюун санааны сайн сайхан байдлыг судлахад чиглэсэн судалгааг энэ удаад хаслаа.



Зураг. 1. Судалгааны хайлт болон сонголт.

Хүснэгт 1. Тандалт судалгаанд ашиглагдсан бүтээлүүдийн тойм

	Судалгааны өгүүллтийн гарчиг	Зохиогч	Жил	Судалгаа хийгдсэн улс	Анхаарч судалсан бүлэг	Гол хүчин зүйлсийг тодорхойлох	Дүгнэлт
1	Ангийн уур амьсгал, хүүхдийн сурлагын болон сэтгэл зүйн сайн сайхан байдал: Системчилсэн болон мета анализ	Ming-Te Wang, Jessica L. Degol, Jamie Amemiya, et al.	2020	Тодорхойлоогүй, мета анализ	Цэцэрлэгийн наснаас ахлах анги хүртэлх хүүхдүүд	Хичээл, зан үйл, нийгэм сэтгэл хөдлөлийн үр дүнтэй холбоотой ангийн уур амьсгал	61 судалгааг хамруулсан тус мета анализ судалгаа нь ангийн уур амьсгал болон сурагчдын үр дүнгийн холбоо

							хамаарлыг судалдаг.
2	Өсвөр үеийнхний сэтгэл зүйн сайн сайхан байдалд хувь нэмэр бий болгодог сургууль дээрх бие даасан байдал, харьяалал, оролцоо	Mark J. Van Ryzin, Amy Gravely, Cary J. Roseth	2009	Тодорхойлоогүй	Өсвөр насныхан	Үндсэн сэтгэл зүйн хэрэгцээ (бие даасан байдал, харьяалагдах байдал, идэвх оролцоо)	Энэхүү судалгаа нь өсвөр насныхны хичээлийн бие даасан байдал, суралцах идэвх болон сэтгэл зүйн сайн сайхан байдалтай холбоотой итгэл найдварын хоорондын холбоо хамаарлыг судалсан.
3	Сэтгэцийн үндсэн хэрэгцээг хангах хүн хоорондын дэмжлэг болон тэдний сэдэл, сайн сайхан байдал, гүйцэтгэлтэй холбогдох холбоо хамаарал: Мета анализ	Gavin R. Slemm, James G. Field, Richard M. Ryan, et al.	2024	Тодорхойлоогүй, мета анализ		Бие даасан байдал, өөрийн ур чадварт итгэх итгэл, бусадтай харилцаа холбоотой байх зэрэгт хүн хоорондын дэмжлэг	Тус мета анализ судалгаа нь 881 судалгааг түүвэр болгосон ба хүн хоорондын дэмжлэг нь сэтгэл зүйн үндсэн хэрэгцээг хангадаг ба өөрийн хүсэл тэмүүлээ тодорхойлох, сайн сайхан байдал болон гүйцэтгэлийг сайжруулдаг болохыг харуулсан (Slemm et al., 2024).
4	Сэтгэл зүйн сайн сайхан байдлын хувьд ялгаварлан гадуурхат мэдрэхийн үр дүн: Мета анализ	Michael T. Schmitt, Nyla R. Branscombe, Tom Postmes, et al.	2014	Тодорхойлоогүй, мета анализ		Ялгаварлан гадуурхалтын мэдрэмж болон сэтгэл зүйн сайн сайхан байдал	Мэдрэгдэж буй ялгаварлан гадуурхалт болон сэтгэл зүйн сайн сайхан байдлын хамаарлыг судалсан.
5	Биеийн тамир болон сургуулийн спорт дахь сэтгэл зүйн сайн сайхан байдал: Системчилсэн судалгаа	Javier Piñeiro-Cossio, Antonio Fernández Martínez, Alberto Nuviala Nuviala, et al.	2021	Тодорхойлоогүй	Хүүхэд болон өсвөр насныхан		Энэхүү судалгаа нь биеийн тамир, сургуулийн спортод сэтгэл зүйн сайн сайхан байдлыг сайжруулах арга хэмжээний талаар дүн шинжилгээ хийдэг.
6	Хүүхэд насны зовлон, зүдгүүрийн туршлага болон амьдралын сэтгэл ханамж, сэтгэл зүйн сайн сайхан	Elise Mosley-Johnson, Emma Garacci, Nick Wagner, et al.	NS	Америк	Насанд хүрэгчид	Хүүхэд насны зовлон зүдгүүртэй туршлага, амьдралын сэтгэл ханамж, сэтгэл зүйн сайн сайхан байдал	Уг судалгаа нь насанд хүрэгчдийн хүүхэд насны зовлон, зүдгүүрийн туршлага

	байдал, нийгмийн сайн сайхан байдлын хоорондын хамаарлыг үнэлэх нь: АНУ-ын 1995–2014 урт хугацааны судалгаа					болон нийгмийн сайн сайхан байдал	болон амьдралын сэтгэл ханамж, нийгмийн сайн сайхан байдлын хоорондын хамаарлыг судалдаг.
7	Боурдинг сургуулийн өсвөр насныхны эцэг эхийн сэтгэл зүйн хараа хяналт, хүүхдийн бие даах хэрэгцээний бухимдал, тэдний сэтгэл зүйн сайн сайхан байдал	Zahrah Aulianissa Manindjo, Vidya Anindhita, Fitri Ariyanti Abidin	2023	Тодорхойлоогүй	Боурдинг сургуулийн өсвөр насны сурагчид	Эцэг эхийн зүгээс ирэх сэтгэл зүйн дарамт, хяналт, бие даасан байдалтай холбоотой бухимдал болон сэтгэл зүйн сайн сайхан байдал	Энэхүү судалгаа нь боурдинг сургуульд суралцаж буй сурагчдын эцэг эхийн зүгээс ирэх сэтгэл зүйн дарамт, хяналт, сурагчийн бие даасан байдалтай холбоотой бухимдал болон сэтгэл зүйн сайн сайхан байдлын холбоо хамаарлыг судалсан болно.
8	Сургуулийн бага насны хүүхдийн сайн сайхан байдалд нийгэм, эдийн засгийн байр суурийн хэсэг	Lisbeth Loft, Jane Waldfogel	NS	Дани	6-11 насны хүүхдүүд	Нийгэм эдийн засгийн байдал болон сургууль дээрх сэтгэл зүйн сайн сайхан байдал	Сурагчдын сэтгэл зүйн сайн сайхан байдал дээрх нийгэм, эдийн засгийн байр суурийн хэсгийг судалдаг.
9	Дасан зохицох чадвар, бие хүний онцлог шинж, нийгмийн дэмжлэг: Хятад ахлах сургуулийн сурагчдын сэтгэл зүйн сайн сайхан байдлын холбоо хамаарлыг судлах нь	Andrew Holliman, Feifei Cheng, Daniel Waldeck	NS	Хятад	Ахлах сургуулийн сурагчид	Дасан зохицох чадвар, онцлог шинж, нийгмийн дэмжлэг, сэтгэл зүйн сайн сайхан байдал	Энэхүү судалгаа нь Хятадын ахлах сургуулийн сурагчдын онцлог шинж, мэдрэгдэж буй нийгмийн дэмжлэг, дасан зохицох чадвар болон сэтгэл зүйн сайн сайхан байдлын хамаарлыг судалсан.
10	Олон улсын сурагчдын мэдрэгдэж буй нийгмийн дэмжлэг, сэтгэл зүйн сайн сайхан байдал: Сэтгэл зүйн уян хатан байдал болон оюун санааны зуучлалын нөлөө	Qi Li, Samsilah Roslan, Zeinab Zaremohzzabieh	2021	Малайз	Хятадын олон улсын сурагчид	Нийгмийн дэмжлэг, сэтгэл зүйн сайн сайхан байдал, сэтгэл зүйн уян хатан байдал, оюун санааны хувьд гэгээрэх	Энэхүү судалгаа нь Малайз дахь олон улсын сурагчдын нийгмийн дэмжлэг болон сэтгэл зүйн сайн сайхан байдлын хоорондын харилцаанд уян хатан байдал, оюун санааны байдлын зуучлалын

							нөлөөг судалж үзсэн.
11	Дэлгэцийн цаг болон хүүхэд, өсвөр насныхны сэтгэл зүйн сайхан байдлын холбоо хамаарал: Хүн ам зүйд суурилсан судалгааны үр дүн	Jean M. Twenge, W. Keith Campbell	NS	Америк	2-оос 17 насны хүүхэд, өсвөр насныхан	Дэлгэцийн цаг, сэтгэл зүйн сайн сайхан байдал	Энэхүү судалгаа нь АНУ-д хийсэн хүн амд суурилсан судалгааны өгөгдлийг ашиглан хүүхэд, өсвөр үеийнхний дэлгэцийн цаг болон сэтгэл зүйн сайн сайхан байдлын хоорондын хамаарлыг судлан гаргасан.
12	Өсвөр насаас эхлэн өтөл насны эхлэл хүртэл эцэг эх, хүүхдийн харилцаа, үр удмын сэтгэцийн сайн сайхан байдал	Mai Stafford, Diana L. Kuh, Catharine R. Gale, Gita Mishra & Marcus Richards	2015	Их Британи		Эцэг эх, хүүхдийн харилцааны чанар, эерэг сэтгэцийн сайн сайхан байдал	Их Британид явагдсан тус судалгаа нь өсвөр наснаас эхлэн өтөл нас хүртэл эцэг эх, хүүхдийн харилцааны чанар болон үр удамын эерэг сэтгэцийн сайн сайхан байдлын хоорондын хамаарлыг судлахыг зорьсон.
13	Монгол улс дахь сургуулийн уур амьсгал: "What's Happening in This School"-асуулгыг орчуулах, нутагшуулах	David N. Sattler, Diana H. Gruman, Oyundelger Enkhtur, et al.	NS	Монгол	ЕБ сургуулийн 8-12 –р ангийн сурагчид	Сургуулийн уур амьсгал	Энэхүү судалгаа нь Монгол улсын сургуулийн уур амьсгалыг үнэлэх "What's Happening in This School" асуулгыг орчуулан нутагшуулахад чиглэсэн.
14	Хувь хүнээс гадна: Нэгж түвшний эрэлт хэрэгцээ, нөөцийн ажилчдын бүтээмж, эрүүл мэнд, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөллийн системчилсэн дүн шинжилгээ	Marta Roczniawska, Ewelina Smoktunowicz, Cristián Coó, et al.	NS	Тодорхойлоогүй	Ажилчид	Ажилчдын бүтээмж, эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаархи нэгж түвшний шаардлага, нөөц	Энэхүү системчилсэн тойм нь нэгжийн түвшний эрэлт хэрэгцээ, нөөцийн ажилчдын бүтээмж, эрүүл мэнд, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөг судалдаг.
15	Боловсролын байгууллагуудын сэтгэл зүйн сайн сайхан байдлын судалгаа: Системчилсэн тойм судалгаа (Mukhlis et al., 2024)	Hamid Mukhlis, Hasan Hariri, Riswandi, Een Yayah Haenilah, Sunyono, Dina Maulina, Fitriadi	2024	Тодорхойлоогүй		Боловсролын байгууллага дахь сэтгэл зүйн сайн сайхан байдал	Энэхүү тойм нь тухайн улсын боловсролын систем болон нийгэм, эдийн засгийн байдал, сэтгэл зүйн сайн сайхан

							байдлын хооронд хүчтэй хамаарал байгааг тодорхойлсон (Mukhlis et al., 2024). Энэ нь боловсролын орчинд сэтгэлзүйн сайн сайхан байдлыг цогцоор нь судлахын тулд чанарын хандлагыг ашиглах ирээдүйн судалгаа шаардлагатай байгааг харуулж байна.
16	Дижитал хэрэгсэл ашиглах нь сэтгэл зүйн сайн сайхан байдалд нөлөөлдөг үү? 9-12 хүүхдийг хамруулсан эмпирик судалгаа	Helena Bruggemana, Alain Van Hiel, Guido Van Halb, Stefan Van Dongenc	NS	Бельги	9-12 насны хүүхдүүд	Дижитал хэрэгслийн хэрэглээ, сэтгэл зүйн сайн сайхан байдал	Энэхүү судалгаа нь Бельги улсын 9-12 насны хүүхдүүдийн сэтгэл зүйн сайн сайхан байдалд дижитал мэдээллийн хэрэгслийн хэрэглээ хэрхэн нөлөөлж байгааг эмпирик байдлаар шалгасан.

### Хүүхдийн субъектив сайн сайхан байдал ба түүнд нөлөөлдөг хүчин зүйлс

Энэхүү хүүхдийн сайн сайхан байдлын талаарх тандалт судалгаанд субъектив сайн сайхан байдал болон сэтгэл зүйн сайн сайхан байдлыг онцлон судалсан ба үүний дагуу тус судалгаанд ашигласан судалгаа нь хүүхдийн сайн сайхан байдалд нөлөөлдөг олон янзын хүчин зүйлийг судалсан билээ. Хүүхдийн сайн сайхан байдал, амьдралын сэтгэл ханамжид нөлөөлдөг гол хүчин зүйл нь найз нөхөд, эцэг эх болон хүүхдийн хувьд эрхэм хүмүүсээс ирдэг нийгмийн дэмжлэг хэмээн тодорхойлсон байна.

Түүнчлэн, хувь хүний онцлог шинж нь сайн сайхан байдлыг тодорхойлох чухал хүчин зүйл болохыг тогтоосон. Тодруулбал, неоротизмын хэв шинж доогуур, ухамсартай байдал давамгайлсан хүүхдийн дасан зохицох чадвар өндөр байдаг ба энэ нь сэтгэл зүйн сайн сайхан байдлыг сайжруулдаг байна (Holliman et al., 2022). Хүүхдийн сэтгэл зүйн хэрэгцээ буюу бие даах, өөрийн ур чадвартай итгэлтэй байх, бусадтай харилцаа холбоотой байх хэрэгцээг хүн хоорондын дэмжлэгээр хангах нь сайн сайхан байдал, амьдралын сэтгэл ханамж, аз жаргалын түвшнийг сайжруулдаг төдийгүй сэтгэлийн зовуурь, түгшүүрийн түвшин ч буурч байсан (Slemp et al., 2024).

Анги доторх уур амьсгал нь хүүхдийн сайн сайхан байдалд мэдэгдэхүйц нөлөөлдөг байна. Эергээр ч, сөргөөр ч нөлөө үзүүлдэг гэнэ. Тухайлбал, анги болон сургуулийн орчинд хүүхдийн бие даасан болон харьяалагдах хэрэгцээг хангаж өгөх нь тэдний сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, сурлагын хувьд амжилт гаргах түлхүүр болдог төдийгүй хүүхдийн ерөнхий сайн сайхан байдалтай холбоотой сэтгэл зүйн үзүүлэлт болох итгэл найдварыг нэмэгдүүлж байсан **таамагласан** (Van Ryzin et

al., 2007). Харин бие даасан байдал болон харьяалагдах хэрэгцээ нь хангагдаагүй, тийм нөхцөл бүрэлдээгүй ангийн уур амьсгал нь хүүхдийн нийгэм сэтгэл зүйн зовуурь болон түрэмгийлэл, анхаарал болгоомжгүй байдал, дүрэм зөрчих зэрэг сөрөг зан үйлийг нэмэгдүүлдэг ажээ (Wang et al., 2020). Түүнчлэн багаар ажиллах, харьяалагдах, бие даах хэрэгцээг чухалчилдаг биеийн тамир, спортын хөтөлбөр нь хүүхдийг бусадтай харилцаа холбоо тогтоох хэрэгцээг хангаж, улмаар сэтгэл зүйн сайн сайхан байдлыг сайжруулдаг (Piñeiro-Cossio et al., 2021) аж.

Харин, эцэг эхчүүдийн хүүхдэдээ тавьж буй сэтгэл зүйн хараа хяналт буюу өөрсдийн бодол, мэдрэмжээ хүүхдэдээ тулгах байдал нь хүүхдийн бие даах хэрэгцээг хангахад саад учруулдаг бөгөөд үүнээс шалтгаалан бухимдал, стрессийг мэдрэж, улмаар тэдний сэтгэл зүйн сайн сайхан байдал буурдаг болохыг онцолж байна (Manindjo et al., 2023).

Хүүхдийн сайн сайхан байдлыг тодорхойлогч бас нэгэн чухал хүчин зүйл бол гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байр суурь юм. Тодруулбал, нийгэм, эдийн засгийн байр суурь нь хүүхдийн амьдрах орчин, хүрээлэн буй орчны чанар, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг институцийн үйл ажиллагааны чанар болон хүргээмж, гэр бүлийн харилцааны нөхцөл байдалд нөлөө үзүүлдэг. Эдгээр харилцан уялдаатай хүчин зүйлс нь хүүхдийн сэтгэл зүйн болон танин мэдэхүйн хөгжлийг тодорхойлдог юм (Loft & Waldfogel, 2020).

Судалгаагаар, санхүүгийн дарамтаас үл хамааран гэр бүл доторх хүчирхийлэл болон өрхийн асуудалтай байдал буюу тухайлбал гэр бүл салалт, гэр бүлийн хэн нэгэн нас барах зэрэг нь амьдралын сэтгэл ханамж, сэтгэл зүйн болон нийгмийн сайн сайханд урвуу хамааралтай болохыг харуулсан. Энэхүү амьдралын сөрөг туршлагатай холбоотой бухимдал, стрессийг даван туулахад нийгмийн үйл ажиллагаа, харилцаанд оролцуулах байдлаар нийгмийн дэмжлэгийг үзүүлэх нь чухал болохыг онцолсон байдаг (Mosley-Johnson et al., 2018).

### **Хүүхдийн сайн сайхан байдлын судалгаанд хэрэглэгддэг арга зүйн хандлагыг шинжлэх нь**

Хүүхдийн сайн сайхан байдал нь аз жаргал, даван туулах чадвар, бат бөх нийгмийн харилцаа зэрэг эерэг үзүүлэлтүүд болон үүнээс гарах сөрөг үр дагавруудыг хамтад нь багтаасан олон талт үзүүлэлтээр судлагдаж гэмээ нь бүрэн ойлгогдох боломжтой үзэгдэл юм. Судлаачид хүүхдийн сайн сайхан байдлыг үнэлэхдээ субъектив болон объектив үзүүлэлтүүдийг ихэвчлэн хослуулан хэрэглэдэг бөгөөд ингэхдээ хүүхдийн өөрийн субъектив ойлголт мэдрэмж болон амьдралын гадаад нөхцөлт шинжүүдийг хамтад тусгасан байдаг (Das et al., 2020). Субъектив сайн сайхан байдал нь гол төлөв асуулга, үнэлгээний хуудсаар дамжуулан хүүхдийн гэр бүл, сургууль, найз нөхөдтэй холбоотой амьдралынх нь сэтгэл ханамжийг хэмжих замаар тодорхойлогддог (Churchill et al., 2020). Тус аргачлалаар хүүхдийн сэтгэл санааны байдал, ерөнхий сэтгэл ханамжийн талаарх мэдээллийг гаргаж ирдэг (Plantade-Gipch et al., 2023).

Нөгөө талаар, объектив үзүүлэлтүүд нь хүүхдийн бие махбодын эрүүл мэнд, боловсролын түвшин, эдийн засгийн баталгаатай байдал зэрэг бодит байдалтай холбож үнэлгээг хийдэг. Энэ нь хүүхдийн сайн сайхан байдлыг хангах боломжит нөөц бололцоо болон боломжийн талаарх илүү бодит дүр зургийг харуулна. Хүүхдийн сайн сайхан байдлыг судлахад хэрэглэгдэх үнэлгээний арга хэрэгслүүд нь найдвартай, баталгаат чанарыг хангасан байхын зэрэгцээ судлагдаж буй хүн амын талаарх соёлын онцлог байдалд мэдрэмжтэйгээр хандсан байх нь чухал (Rosanbalm et al., 2016).

Мөн судалгааны ёс зүйн үндсэн зарчим нь хүүхдийн нууцлалыг хамгаалж, судалгааны явцад тэдний дуу хоолойг тусгаж өгөх явдал (Kutsar et al., 2018) байх учиртай. Хүүхдээс мэдээлэл цуглуулахдаа тэдний нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохирсон хэл, арга зүйг сонгон ашиглах

шаардлагатайг судлаачид онцлон тэмдэглэсэн байна. Арга зүйн дээрх хүчин зүйлсэд нухацтай хандсанаар судлаачид хүүхдийн сайн сайхан байдлын талаар илүү нарийн, үнэн бодит ойлголттой болж, тэдний эрүүл хөгжилд чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэх боломжтой аж.

Дээр дурдагдсан тоон судалгааны арга ашиглах арга зүйн хандлагаас гадна чанарын судалгааны арга зүйн асуудлыг анхаарах нь зүй. Чанарын судалгаа нь хүүхдийн субъектив туршлага, ойлголтыг судлах онцгой боломж олгодог бөгөөд тэдний сайн сайхан байдлын талаар гүн гүнзгий, нарийн мэдээлэл өгдөг (Kellock, 2020). Ярилцлага, бүлгийн ярилцлага, ажиглалт зэрэг чанарын аргачлал нь хүүхдийн амьдралын нарийн төвөгтэй байдал, тэдний хувьд юу чухал болох, ямар сорилттой хэрхэн нүүр тулж буйг ойлгоход тус болно (Moula et al., 2021).

Түүнчлэн чанарын судалгааны системчилсэн тойм болон тандалт судалгаанууд нь олон тооны судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх замаар нийтлэг сэдэв, хандлагыг тодорхойлоход тустай (Attree, 2004). Цаашилбал, хүүхдийн сайн сайхан байдалтай холбоотой мэдээллийг илүү бүтээлч байдлаар, хүүхдийг судалгааны идэвхтэй оролцогч байдлаар оролцуулан судлах боломжтойгоороо чанарын судалгаа нь давуу талтай (Lane et al., 2019). Үүнд хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон арга зүйг, жишээлбэл өөрийнх нь түүхийг яриулах, зураг зуруулах, тоглоомд суурилсан ярилцлага гэх мэт арга зүйг ашиглах нь тэдний оролцоог нэмэгдүүлж, илүү гүнзгий, олон талт мэдээлэл цуглуулах нөхцөл болдог (Berman & Albright, 2017). Ингэхдээ тоон судалгааны нэгэн адил хүүхдийн болон тэдний эцэг эхийн зөвшөөрлийг авах, нууцлалыг хангах зэрэг ёс зүйн асуудлыг нарийн авч үзэх шаардлагатай. Чанарын судалгааны оролцооны аргын давуу тал нь тоон судалгааны аргаар судлахад орхигдсон мэдээллийг нөхөж, судалгааны асуултыг тодорхойлоход тус болохоос гадна тоон судалгааны үр дүнгийн “яаж?, хэрхэн?” гэх асуултыг тайлбарлахад шаардлагатай мэдээллийг олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг (Jarvie, 2012).

### **Хүүхдийн сайн сайхан байдлыг судлахтай холбоотой ёс зүйн асуудлууд**

Хүүхдийн сайн сайхан байдлын талаарх судалгаа нь хүүхдийн эрүүл хөгжлийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээний үндэс болох тул чухал ач холбогдолтой. Гэхдээ хүүхдүүд өвөрмөц эмзэг бүлэгт хамаарах тул тэдний эрх, нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах ёс зүйн хэм хэмжээг энэ төрлийн судалгаанд ямагт онцгойлон анхаарах шаардлагатай байдаг. Иймдээ ч зарим судлаачид хүүхдийн сайн сайхан байдлын судалгаанд хүүхдийг судалгааны идэвхгүй “субъект” бус, харин оролцогч, эрх бүхий бие хүн хэмээн авч үзэх ёстойг онцолдог (Loft & Waldfogel, 2020).

Хүүхдийн сайн сайхан байдал нь сэтгэл зүйн, нийгмийн, бие махбодын зэрэг хэд хэдэн үзүүлэлтийн нэгдэл бөгөөд эдгээр нь хууль, гэр бүл, боловсрол, эдийн засаг болон эрүүл мэндийн тогтолцоотой нягт уялдаатайгаар судлагддаг (Schües & Rehmann-Sutter, 2013). Энэ тохиолдолд хүүхдийн бие бялдрын онцлог хийгээд сэтгэхүйн хувьд эмзэг байдал нь судалгаанаас үүдэлтэй эрсдэлээс тэднийг хамгаалах шаардлагыг нөхцөлдүүлдэг байна (Ferdousi, 2015). Иймд судалгааны ёс зүйн үндсэн шалгуур нь хүүхдийн асран хамгаалагчаас **зөвшөөрөл (guardians consent) авах** мөн хүүхдээс өөрөөс нь давхар **зөвшөөрөл (assent)**-ийг авах явдал байдаг (Fernandez, 2008). Үүнээс үүдэн судалгааны бүхий л мэдээлэл, түүн дотроо судалгааны хэрэглэгдэхүүнүүд нь судалгаанд хамрагдах хүүхдийн насны онцлогт тохирсон, тэдэнд ойлгогдохуйц байдлаар сайтар боловсруулагдаж бэлтгэгдсэн байх зайлшгүй шаардлагатай аж.

Түүнчлэн судалгаанд оролцох хүүхдийн оролцоо нь зөвхөн сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдах ёстой. Энэ нь, хэрэв оролцогч хүүхэд хүсвэл хэзээ ч судалгааны үйл явцыг орхиж болно гэдгийг ойлгосон байх нөхцөл дор судалгаа хийгдэх ёстойг судлаачид зөвлөдөг байна (Larkins, 2013;

Wolbransky et al., 2013). Ялангуяа эмзэг мэдээлэлтэй харьцах үед нууцлалыг чанд сахих шаардлагатай бөгөөд хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээг судлаачид авч хэрэгжүүлэх ёстой (Askari et al., 2024). Өөрөөр хэлбэл ёс зүйн хэм хэмжээний хүрээнд тухайн орны хууль эрх зүй, соёл, нийгмийн орчныг харгалзан үзэхээс гадна хүүхдийн хөгжлийн үе шат, шийдвэр гаргах чадамж зэрэг нөхцөл байдлыг нарийн тооцсон байх шаардлагатай (Askari et al., 2024).

Түүнчлэн, олон соёлт судалгаанд соёлын мэдрэмжтэй байх нь нэн чухал. Судлаачид оролцогчдын соёлын үнэт зүйлс, ёс заншлыг хүндэтгэж, өөрсдийн өрөөсгөл таамаглал, дүгнэлтийг тулгахгүй байх хэрэгтэй (Loft & Waldfogel, 2020) болно. Энэ нь судалгааны ёс зүйн integrity болон бодит байдалд нийцэх байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой билээ.

### Дүгнэлт

Бид энэхүү судалгаагаар хүүхдийн сайн сайхан байдлын олон талт ойлголт, бүтцийн талаарх судалгаануудыг нэгтгэж, асуудлыг хөндөн хэлэлцүүлэхийг зорьсон. Тойм судалгааны үр дүнгээр хүүхдийн сайн сайхан байдалд өргөн хүрээний эх сурвалжтай нийгмийн дэмжлэг жинтэй нөлөөлдөг болохыг тогтоосон. Дүн шинжилгээ, анализ хийсэн судалгааны дийлэнх нь нарийн, тоон судалгааны загварыг ашиглаж хийгдсэн байна. Тодруулбал, тухайн агшны харьцуулсан **бүлгийн** судалгаа, урт хугацааны судалгаа, нутагшуулалтын судалгаа, мета-анализ, системчилсэн судалгаа зэрэг олон төрлийн судалгааны загварыг ашигласан судалгаанууд бидний сонгон авсан бүтээлүүдэд таарч байсан.

Ерөнхийдөө энэхүү тандалт судалгаа нь хүүхдийн сайн сайхан байдлын талаарх судалгаануудын үр дүнг багтаасан. Тус судалгаанууд нь нийгмийн дэмжлэг нь хүүхдийн сайн сайхан байдал цаашлаад хувийн туршлага болон сэтгэл зүйн эрүүл мэндэд маш чухал болохыг онцолж байсан. Судалгааны үр дүнгээс харахад сайн сайхан байдал нь хүүхдийн нийгмээс авч буй дэмжлэг, хувь хүний онцлог шинж, сэтгэл зүйн үндсэн хэрэгцээг хангахуйц сургуулийн болон ангийн орчинтой эерэг холбоо хамааралтай хэмээн үзэж болох аж. Үүний зэрэгцээ, эцэг эхээс авч буй дарамт, хяналт, гэр бүлийн асуудал, нийгэм эдийн засгийн байр суурийн доогуур байдал нь сайн сайхан байдлыг дордуулж, сургуулийн орчин дахь сөрөг зан үйлийг нэмэгдүүлдэг. Энэхүү судалгаанаас үзэхэд хүүхдийн сайн сайхан байдлын олон талт байдал болон нийгэм, хүрээлэн буй орчин дахь хүчин зүйлсийн сайн сайхан байдалд үзүүлэх гол үүрэг, оролцоог онцолж байна хэмээн дүгнэж байна.

Энэхүү судалгаа нь хүүхдийн сэтгэл зүйн болон субъектив сайн сайхан байдлын талаарх судалгаа, шинжилгээг хамарсан ба тодорхой хязгаарлалт, цоорхой байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тус тоймд багтсан дийлэнх судалгаа нь нэг үе шатны **огтлолын** болон урт хугацааны зэрэг тоон үзүүлэлт дээр суурилсан аргууд байсан бөгөөд чанарын өгөгдөлд тулгуурлан хүүхдийн сайн сайхан байдлыг тодорхойлох судалгаа хомс байв. Тиймээс ирээдүйн сайн сайхан байдлын судалгаанд хүүхдийн туршлага, тэдний харах өнцгийн талаарх ойлголтыг баяжуулах тоон болон чанарын арга зүйн ач холбогдлын талаар харгалзан үзэх нь зүйтэй байна. Тодруулбал, тоон болон чанарын аргуудыг нэгтгэсэн судалгааны санг нэмэгдүүлэн, янз бүрийн нийгмийн нөхцөл байдал дахь хүүхдийн сайн сайхан байдлыг судлах, ёс зүйн хувьд үндэслэлтэй арга зүйг ашиглахыг судалгааны хүрээнд онцолж байна.

Судалгааны бас нэг хязгаарлалттай тал бол Азийн соёл дээр суурилсан, Азийн орнуудад хийгдсэн судалгаа хомс байгаа явдал бөгөөд энэхүү соёлын хүчин зүйл нь хүүхдийн сайн сайхан байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг байж болзошгүй билээ.

Мөн хүүхдийн сайн сайхан байдлыг судлахдаа ёс зүйн хэм хэмжээг тодорхой түвшинд авч үзэх шаардлагатай болохыг судалгаанууд харуулсан. Тодруулбал, судалгааны үеийн ёс зүйн хэм хэмжээ,

хүүхдийн хөгжлийн үе шат, шийдвэр гаргах чадвар, эрүүл мэндийн байдал, нийгэм, соёлын орчин зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж судалгааг хийх нь зүйтэй ажээ. Тиймээс, цаашдын судалгаанууд нь соёлын мэдрэмжтэй байдлыг соёл хоорондын ялгаатай нөхцөл байдалд нэн тэргүүнд тавьж арга зүйгээ боловсруулах хэрэгтэй ба тус арга зүй нь хүүхдийн амьдралын ялгаатай туршлага, тэдний сайн сайхан байдлын талаарх үзэл бодлыг үнэн зөв илрүүлэхүйц нас, хөгжлийн онцлогт тохирсон байхад анхаарах нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

### **Хэлэлцүүлэг**

Энэхүү тандалт судалгаагаар хүүхдийн сэтгэл зүй сайн сайхан байдалд нөлөөлөгч хүчин зүйлсэд анхааран, хүүхдийн субъектив сайн сайхан байдлын талаарх өнөөгийн судалгаануудын агуулгад шинжилгээ хийсэн. 19 судалгааны өгүүлэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнд дараах гол сэдвүүд болон асуудлуудыг тодруулсан болно. Үүнд:

#### **1. Нийгмийн дэмжлэг – Суурь нөлөөлөгч хүчин зүйл**

Эцэг эх, найз нөхөд, эргэн тойрны хүмүүсийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн дэмжлэг нь хүүхдийн сэтгэл зүйн сайн сайхан байдалд хамгийн ихээр нөлөөлдөг болох нь олон судалгаагаар нотлогдсон. Хүчтэй нийгмийн холбоо хамаарал, дотно харилцаа нь сэтгэл санааны тэнцвэрийг хадгалах, сэтгэл түгшилтийг бууруулах, амьдралын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй аж.

#### **2. Сургуулийн орчин ба бие даасан байдал**

Бие даасан байдал, хамтач үзэл, идэвхтэй оролцоог дэмжсэн эерэг сургалтын орчин нь хүүхдийн сэтгэл зүйн зохицол, хичээлд оролцох идэвх, ерөнхий сайн сайхан байдалд эергээр нөлөөлж байна. Харин хүүхдийн сэтгэл хөдлөл, хөгжих хэрэгцээг үл тоомсорлосон сургалтын орчин нь сэтгэл зүйн дарамт болон сөрөг зан үйлийн илрэлүүдийг нэмэгдүүлдэг байна.

#### **3. Эцэг эхийн нөлөө**

Хүүхдийн бие даасан байдлыг хязгаарлах, сэтгэл зүйн хяналт давамгайлсан эцэг эхийн хандлага эсвэл харилцааны хэв маяг нь өсвөр насныхны сайн сайхан байдалд сөрөг нөлөө үзүүлдэг. Харин сэтгэл санааны хувьд дэмжсэн, ойлгож хандсан хүмүүжил нь хүүхдийн өөртөө итгэх итгэл, сэтгэл зүйн тогтвортой байдлыг нэмэгдүүлдэг байна.

#### **4. Нийгэм-эдийн засгийн байдал ба бүтцийн хүчин зүйлс**

Хүүхдийн амьдралын нөхцөл байдал-гэр бүлийн орлого, боловсролын хүртээмж, хөршийн аюулгүй байдал зэргээс шалтгаалан сайн сайхан байдалд ихээхэн нөлөөлдөг. Эдгээр бүтцийн тэгш бус байдал нь зөвхөн материаллаг нөхцөл байдлыг төдийгүй хүүхдийн сэтгэл зүйн хөгжил, амьдралын чанарт шууд нөлөөлж байна.

#### **5. Соёл, газар зүйн судалгааны хомс байдал**

Судалгаанд ашиглагдсан 19 эх сурвалжаас ердөө нэг нь Монголд хийгдсэн байсан нь энэ чиглэлээрх дотоодын судалгаа туйлын хомс байгааг харуулж байна. Монголын уламжлалт гэр бүлийн бүтэц, боловсролын орчин, соёлын хэв маяг хүүхдийн сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

#### **6. Арга зүйн сургамжууд**

Хүүхдийн сайн сайхан байдлыг судлахад тоон болон чанарын аргуудыг хослуулах нь үр дүнтэй болохыг энэ тойм харуулж байна. Тоон судалгаа нь ерөнхий чиг хандлагыг тодорхойлдог бол чанарын арга-ярилцлага, хувийн түүх хүүрнэх, зурган оролцоотой аргууд нь хүүхдийн дотоод мэдрэмж, туршлагыг илүү нарийн, гүн гүнзгий илэрхийлэх боломжтой. Ийм хосолмол арга нь хүүхдийн сайн сайхан байдлын иж бүрэн ойлголтыг бүрдүүлэхэд тустай байх боломжтой. Тэдгээр аргуудыг бүтээлчээр ашиглаж, судалгаанд ашиглах оролдлогуудыг эхлэх шаардлагатай байна.

### **Ашигласан материал**

- Attree, P. (2004). Growing up in disadvantage: a systematic review of the qualitative evidence [Review of Growing up in disadvantage: a systematic review of the qualitative evidence]. *Child Care Health and Development*, 30(6), 679. Wiley. <https://doi.org/10.1111/j.1365-2214.2004.00480.x>
- Aulia, F., Hastjarjo, T. D., Setiyawati, D., & Patria, B. (2020). Student Well-being: A Systematic Literature Review. *Buletin Psikologi*, 28(1), 1. <https://doi.org/10.22146/buletinpsikologi.42979>
- Bertram, H. (2016). Kindliches Wohlbefinden: Von Kinderarmut und Fürsorge zur kindlichen Teilhabe. *Diskurs Kindheits- Und Jugendforschung / Discourse Journal of Childhood and Adolescence Research*, 11(3), 269. <https://doi.org/10.3224/diskurs.v11i3.2>
- Bruggemana, H., Hiel, A. V., Halb, G. V., & Dongen, S. V. (n.d.). Does the use of digital media affect psychological well-being? An empirical test among children aged 9 to 12 ☆.
- Churchill, S. A., Farrell, L., & Appau, S. (2020). Measuring, Understanding and Improving Wellbeing Among Older People. In Springer eBooks. Springer Nature. <https://doi.org/10.1007/978-981-15-2353-3>
- Das, K., Jones-Harrell, C., Fan, Y., Ramaswami, A., Orlove, B., & Botchwey, N. (2020). Understanding subjective well-being: perspectives from psychology and public health [Review of Understanding subjective well-being: perspectives from psychology and public health]. *Public Health Reviews*, 41(1). Springer Science+Business Media. <https://doi.org/10.1186/s40985-020-00142-5>
- Demiessie, H., & Shirin, S. (2021). The Gateway to Well-being and Happiness: Re-defining Individualism, Voluntary Simplicity and Civilization. *Asian Journal of Social Sciences and Legal Studies*, 59. <https://doi.org/10.34104/ajssls.021.059074>
- Euillet, S. (2020). Foster care in France: children's perception of their own well-being. *Child & Family Social Work*, 25, 160. <https://doi.org/10.1111/cfs.12743>
- Grīga, L. (2016). Promoting children's wellbeing in an educational context. *Problemy Wczesnej Edukacji*, 32(1), 148. <https://doi.org/10.5604/01.3001.0008.5643>
- Jarden, A., & Roache, A. (2023). What Is Wellbeing? *International Journal of Environmental Research and Public Health*, 20(6), 5006. <https://doi.org/10.3390/ijerph20065006>
- Jarvie, W. (2012). Qualitative Research in Early Childhood Education and Care Implementation. *International Journal of Child Care and Education Policy/International Journal of Child Care and Education*, 6(2), 35. <https://doi.org/10.1007/2288-6729-6-2-35>
- Holliman, A., Cheng, F., & Waldeck, D. (2022). Adaptability, personality, and social support: Examining links with psychological wellbeing among Chinese high school students. *International Journal of Educational Psychology*, 11(2). <https://doi.org/10.17583/ijep.8880>
- Kellock, A. (2020). Children's well-being in the primary school: A capability approach and community psychology perspective. *Childhood*, 27(2), 220. <https://doi.org/10.1177/0907568220902516>
- Kemppainen, T. (2012). Well-being in socio-political context. *European welfare regimes in comparison*. <https://helda.helsinki.fi/handle/10138/37306>
- Kiefer, R. A. (2008). An Integrative Review of the Concept of Well-Being [Review of An Integrative Review of the Concept of Well-Being]. *Holistic Nursing Practice*, 22(5), 244. Lippincott Williams & Wilkins. <https://doi.org/10.1097/01.hnp.0000334915.16186.b2>
- Kutsar, D., Soo, K., Strózik, T., Strózik, D., Grigoraş, B., & Bălăţescu, S. (2018). Correction to: Does the Realisation of Children's Rights Determine Good Life in 8-Year-Olds' Perspectives? A Comparison of Eight European Countries. *Child Indicators Research*, 12(1), 185. <https://doi.org/10.1007/s12187-018-9555-2>
- Lane, D., Blank, J., & Jones, P. (2019). Research with Children: Context, Power, and Representation. *The Qualitative Report*. <https://doi.org/10.46743/2160-3715/2019.3556>
- Li, Q., Roslan, S., & Zaremohzzabieh, Z. (2021). Perceived Social Support and Psychological Well-Being of International Students: The Mediating Effects of Resiliency and Spirituality. *Asian Journal of University Education*, 17(3), 220. <https://doi.org/10.24191/ajue.v17i3.14502>
- Loft, L., & Waldfoegel, J. (2020). Socioeconomic status gradients in young children's Well-being at school. *Child Development*, 92(1). <https://doi.org/10.1111/cdev.13453>

- Manindjo, Z. A., Anindhita, V., & Abidin, F. A. (2023). Parental Psychological Control, autonomy frustration, and psychological well-being among boarding school adolescents. *Journal of Education and Learning (EduLearn)*, 17(2), 262–270. <https://doi.org/10.11591/edulearn.v17i2.20734>
- Mosley-Johnson, E., Garacci, E., Wagner, N., Mendez, C., Williams, J. S., & Egede, L. E. (2018). Assessing the relationship between adverse childhood experiences and life satisfaction, psychological well-being, and social well-being: United States Longitudinal cohort 1995–2014. *Quality of Life Research*, 28(4), 907–914. <https://doi.org/10.1007/s11136-018-2054-6>
- Moula, Z., Walshe, N., & Lee, E. (2021). Making Nature Explicit in Children’s Drawings of Wellbeing and Happy Spaces. *Child Indicators Research*, 14(4), 1653. <https://doi.org/10.1007/s12187-021-09811-6>
- Mukhlis, H., Hariri, H., Riswandi, R., Haenilah, E. Y., Sunyono, S., Maulina, D., & Fitriadi, F. (2024). A current study of psychological well-being in educational institutions: A systematic literature review. *Journal of Education and Learning (EduLearn)*, 18(2), 382. <https://doi.org/10.11591/edulearn.v18i2.21136>
- NG, W. L. (2021). Understanding how Democracy Shapes Well-Being of Countries in Europe and Asia.
- Norozi, S. A. (2023). The Nexus of Holistic Wellbeing and School Education: A Literature-Informed Theoretical Framework. *Societies*, 13(5), 113. <https://doi.org/10.3390/soc13050113>
- Piñeiro-Cossio, J., Fernández-Martínez, A., Nuviola, A., & Pérez-Ordás, R. (2021). Psychological wellbeing in physical education and school sports: A systematic review. *International Journal of Environmental Research and Public Health*, 18(3), 864. <https://doi.org/10.3390/ijerph18030864>
- Plantade-Gipch, A., Bruno, J., Strub, L., Bouvard, M., & Martin-Krumm, C. (2023). Emotional regulation, attachment style, and assertiveness as determinants of well-being in emerging adults. *Frontiers in Education*, 8. <https://doi.org/10.3389/feduc.2023.1058519>
- Richter, N., Bondü, R., Spieß, C. K., Wagner, G. G., & Trommsdorff, G. (2018). Relations Among Maternal Life Satisfaction, Shared Activities, and Child Well-Being. *Frontiers in Psychology*, 9. <https://doi.org/10.3389/fpsyg.2018.00739>
- Rosanbalm, K. D., Snyder, E. H., Lawrence, C., Coleman, K., Frey, J., Ende, J. B. van den, & Dodge, K. A. (2016). Child wellbeing assessment in child welfare: A review of four measures [Review of Child wellbeing assessment in child welfare: A review of four measures]. *Children and Youth Services Review*, 68, 1. Elsevier BV. <https://doi.org/10.1016/j.childyouth.2016.06.023>
- Sattler, D. N., Gruman, D. H., Enkhtur, O., Muskavage, B., & Бишхорлоо, Б. (2021). School climate in Mongolia: Translation and validation of the What’s Happening in This School. *Learning Environments Research*, 25(2), 325. <https://doi.org/10.1007/s10984-021-09375-w>
- Slemp, G. R., Field, J. G., Ryan, R. M., Forner, V. W., Van den Broeck, A., & Lewis, K. J. (2024). Interpersonal supports for basic psychological needs and their relations with motivation, well-being, and performance: A meta-analysis. *Journal of Personality and Social Psychology*, 127(5), 1012–1037. <https://doi.org/10.1037/pspi0000459>
- Stafford, M., Kuh, D. L., Galé, C. R., Mishra, G. D., & Richards, M. (2015). Parent–child relationships and offspring’s positive mental wellbeing from adolescence to early older age. *The Journal of Positive Psychology*, 11(3), 326. <https://doi.org/10.1080/17439760.2015.1081971>
- Van Ryzin, M. J., Gravely, A. A., & Roseth, C. J. (2007). Autonomy, belongingness, and engagement in school as contributors to adolescent psychological well-being. *Journal of Youth and Adolescence*, 38(1), 1–12. <https://doi.org/10.1007/s10964-007-9257-4>
- Twenge, J. M., & Campbell, W. K. (2018). Associations between screen time and lower psychological well-being among children and adolescents: Evidence from a population-based study. *Preventive Medicine Reports*, 12, 271. <https://doi.org/10.1016/j.pmedr.2018.10.003>
- Wang, M.-T., L. Degol, J., Amemiya, J., Parr, A., & Guo, J. (2020). Classroom climate and children’s academic and psychological wellbeing: A systematic review and meta-analysis. *Developmental Review*, 57, 100912. <https://doi.org/10.1016/j.dr.2020.100912>